

МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР ОНӨТҮГ
МАРКЕТИНГИЙН ХЭЛТСИЙН 2014 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН
ГҮЙЦЭТГЭЛ

- Жилд болох баяр наадам бусад арга хэмжээ, судалгаа
- Үндэсний ёс заншил
- Монгол наадам цогцолборт дагалдах бизнесийн судалгаа
- Монгол улсын спортын ордон, хүн амын багтаамж цар хүрээ
/Хүй долоон худагт болсон баяр наадам/
- Шинээр санаачилсан ажил

Боловсруулсан:

Спорт, аялал жуулчлалын мэргэжилтэн

Д.Өлзийсайхан

Соёл урлаг хариуцсан мэргэжилтэн

Б.Солонго

Гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн

Ц.Нямдэлгэр

Хянасан:

Захиалагч менежер

М.Жаргалсайхан

2015 он

➤ **Жилд болох баяр наадам бусад арга хэмжээ, судалгаа**

Хүй долоон худгийг жилийн турш тасралтгүй үйл ажиллагаатай амралт, зугаалгын цогцолбор болгохоор Монгол наадам цогцолборын А,Б зогсоолын баруун талд үзэсгэлэн, худалдаа, амралт зугаалгын хэсгийг төлөвлөн ажиллаж байна.

2014 оны байдлаар Хүй долоон худагт зохион байгуулагдсан баяр наадам, тэмцээн уралдаан

- ✚ Дрифтын улсын аварга шалгаруулах тэмцээн 4 дүгээр сар 19 өдөр
- ✚ Дрифтын тэмцээн 5 дугаар сар 17 өдөр
- ✚ Төр улсын хөгжил түмэн олны үйлс чуулган 5 сарын 28 өдөр
- ✚ Үндэсний Их Баяр Наадам 7 сарын 11-13 өдөр
- ✚ УБЦТС компаний баяр
- ✚ Адуучин 2014 тэмцээн 8 сарын 23 өдөр
- ✚ Эрүүл иргэн –Эко хөгжил зуны дугуйн аялал, амралт зугаалгын өдөрлөг 8 сарын 30-аас 10 сарын 04 өдөр
- ✚ Үндэсний спортын V-р их наадам 9 сарын 10-13 өдөр
- ✚ Шилмэл мал 2014 үзэсгэлэн 9 сарын 11-13 өдөр

➤ **Үндэсний ёс заншил**

“Монгол Наадам- 2014” теле зохиомж, видео бичлэг хийв. Улсын их баяр наадмын үеэр “Хүй долоон худаг”-т Монгол түмэн хэрхэн нэг дор цугларан наадмаа хийдгийг харуулсан 3 минутын теле бичлэг хийсэн. Дараа дараагийн үйл ажиллагаанд зориулан дүрс архивлан бэлтгэв.

ШУАТХ хамтран Монгол наадам цогцолборын дэргэдэх албан бус эрдэмтдийн зөвлөл байгуулан ажиллаж байна. Уг зөвлөлд МШУАТХ-ийн доктор, профессорууд, урлаг судлаач доктор, Аялал жуулчлалын сургалт судалгааны доктор профессорууд оролцож Монгол наадмын өнгө, бэлгэдэл, түүхийн талаар мэдээлэл өгч байна.



Монголчуудын өв соёл, түүх, зан заншилтай холбоотой Монголын Үндэсний Сурын холбоотой хамтран үндэсний сурын төрөл орон зай хамрах хүрээ зэргийг судлав.

Монголын дүрслэх урлагийн нэгдсэн холбоотой хамтарч эрийн гурван наадмын хурдан морь, сур харваа, хүчит бөхийн шүтээн цогцолборын бэлгэдлийн загварыг гаргаж эхлэв. Хурдан морины шүтээний зураг гарав.



Хурдан морины шүтээний хувилбар-1



Хурдан морины шүтээний хувилбар-2

➤ **Монгол улсын спортын ордон, хүн амын багтаамж цар хүрээ**

Монгол наадам цогцолборт баригдах төв стадион 30,000 хүний суудалтай, морь барианы газар 15,000 хүний суудалтайгаар төлөвлөх зэргийн төлөвлөлтөд санал өгөв.

Улаанбаатар хотод Монгол улсын хүн амын 50 гаруй хувь нь оршин суудаг, нийт хүн амын 75 хувийг нь хүүхэд, залуус эзэлдэг бөгөөд олон нийтэд зориулсан өвлийн аялал, амралт, зугаалгын төвүүд хомс байдаг.

Хэдийгээр их хотод өвлийн спортыг хөгжүүлэх нөөц боломж байдаг боловч спортын бэлтгэл бааз суурийн багтаамж хязгаарлагдмал байна. Хотын хэмжээнд томоохонд тооцогдох Скай ресорт цанын бааз нь өдөрт 4000 хүн хүлээж авах чадалтай боловч тариф өндөр, үйлчлүүлэгчдийн хүрээлэл хязгаарлагдмал, Хандгайтын цанын баазын хувьд автомашины зогсоолын талбайгүй, зоогийн газар, ариун цэврийн газар нь тухгүй зэрэг шалтгаануудаас 1,5 сая хүн амтай манай хотын хувьд өвлийн спортын хүчин чадал, амралт зугаалгын газрууд дутагдаж байна. Иймээс энэхүү салбарыг хөгжүүлэх зайлшгүй шаардлага урган гарч байна.

Өвлийн цанын баазад зориулж үйлчилгээний байр, цана, тэшүүрийн талбай хийх үнэ, түрээсийн үнийн саналыг судлав. Их хотын иргэдийн өвлийн улиралд амарч, зугаалах, спортоор хичээллэх боломжийг судлав. Скай ресорт өдөрт 4000 хүн хүлээн авах боломжтой үнийн хувьд өндөр, Хандгайтын цанын бааз 200-400 гулгах боломжтой боловч бие засах газар, хоолны газар шаардлага хангахгүй зэрэг нь нийслэл хотын хэмжээнд өвлийн спортын цар хүрээ, багтаамж нийт иргэдийн 1%-д хүрэхгүй байгааг харуулж байна.

Манай оронтой уур амьсгалаар ижил төстөйд тооцогдох Канад, Швед зэрэг европын орнууд нь газар нутгийн хэмжээгээрээ харьцангуй бага боловч ард түмнийхээ чөлөөт цаг, аялал амралтад зориулсан өвлийн спорт, аялал, амралтын цогцолборуудыг их хэмжээгээр байгуулан хөгжүүлсэн байдаг. Манай орны тамирчдын хувьд өвлийн спортоор түлхүү хичээллэн өвлийн олимп, дэлхийн тэмцээн уралдаанд амжилт гаргах боломж байдаг хэдий ч бид төдийлөн анхаарал хандуулдаггүй.

Бид нийслэл хотынхоо дөрвөн зүгт Богдхаан уул, Сонгинохайрхан уул гэх мэт гадаад, дотоодын иргэд, жуулчдын сонирхлыг татсан түүх, соёлын дурсгалт, цэвэр агаартай цанын бааз байгуулахуйц байгалийн тогтоц сайтай өндөрлөг уул, налуу амуудаар хүрээлэгдсэн байдаг. Энэхүү байгаа нөөц боломжийг оновчтой ашиглах замаар өвлийн спортын салбарыг хөгжүүлэх, улмаар өвлийн аялал, амралт, зугаалгын цогц үйлчилгээ бүхий үнийн уян хатан нөхцөлтэй, олон нийтийн чиглэлийн өвлийн цогцолборыг Хүйн долоон худагт байгуулах шаардлагатай байна.

➤ **Монгол наадам цогцолборт дагалдах бизнесийн судалгаа**

Монгол наадам цогцолборт зохион байгуулагдаж байгаа тэмцээн уралдаан, баяр наадмын үед хоол үйлчилгээ, худалдаа үйлчилгээний цэгүүдийг дүүргүүдийн Нийтийн хоол, худалдаа үйлчилгээний мэргэжилтнүүдээс гарах сонирхолтой аж ахуй нэгж, иргэдийн хүсэлтийг нэгтгэн авч мэдээллийн санг бүрдүүлэн баяр ёслолын үед хамтран ажиллаж байна. Мөн Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ-ын эзэмшлийн сандал, асар, тог цахилгааны тарифыг Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар оруулан үнийн тарифыг батлуулан ажиллаж байна. Үнийн тарифыг хавсаргав:

Нийслэл хотын иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор өвлийн улиралд цана, чаргаар гулгах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

Хүйн долоон худаг Монгол наадам цогцолбор нь өөрийн жуулчны баазыг байгуулж байна. Бааз нь 12 зочны гэр, 10 ханатай гэр ресторанаас бүрдэнэ. Баазад буух зочид билльярд, ширээний теннис, зоогийн газраар үйлчлүүлэх боломжтой байхаар төлөвлөн ажиллаж байна.

Дрифтын тэмцээн

Энэ оны хамгийн анхны дрифт шоу 2014 оны 4 сарын 19 нд Хүй долоон худагт аюулгүй байдлыг дээд зэргээр сахиж, зохион байгуулалтын өндөр түвшинд болсон энэ удаагийн "VIP Drift" шоунд 18 клубын 60 гаруй тамирчин хурд, авъяас чадвараа сорьсон юм. Ингээд тэмцээнд оролцогчдоос хурд хүч, авхаалж самбаа, ур чадвараараа "V-6" клубын тамирчин О.Ууганхүү тэргүүлсэн бол хоёрдугаар байрт "Drift work" клубын тамирчин н.Баянмөнх, гуравдугаар байрт "Speed Sick" н.Бат-Очир, тусгай байрт Монголын анхны эмэгтэй дрифтчин Д.Болортуяа шалгарсан юм.

Энэ жил тусгай байрт шалгарсан Д.Болортуяагын хувьд залуустай эн зэрэгцэхүйц өрсөлдөж байсан бөгөөд энэ жил түүний ур чадвар мэдэгдэхүйц нэмэгдсэн байлаа. Түүний хувьд энэ төрлөөр чамгүй удаан хичээллэж байгаа Монголын ирээдүйтэй тамирчинд тооцогддог анхны эмэгтэй дрифтчин юм.

Тус шоуны салхийг хагалж, агаарын үзүүлэх тоглолтууд, циркийн болон мотоспортын үзүүлбэрүүд, удирдлагатай машины уралдаан зэрэг залуусыг байлдан дагуулсан гайхалтай үзүүлбэрүүдээр дүүрэн байсан бөгөөд энэ удаагийн шоу "Андра модель" агентлагийн загвар өмсөгч, үзэсгэлэнт охид чимсэн юм.

Өндөр зохион байгуулалттай болсон энэ удаагийн наадмын үеэр нэг ч авто осол гараагүй бөгөөд архи согтууруулах ундаа хэрэглэсэн залуус байгаагүй, талбайн тохижилт сайн, хоггүй байсныг онцлох нь зүйтэй болов уу.





Монгол цэргийн жавхаа

БХЯ болон НЗДТГ-ын Цэргийн штабтай хамтран 5 сарын 01-04 өдөр хүртэл Чингисийн талбай дээр 2000 сандал угсарч, үйл ажиллагаа дээр хяналт тавин ажиллав. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Э.Бат-Үүл “Монгол цэргийн жавхаа” уралдааныг энэ оны эхээр зарласнаас хойш тэргүүний жагсаалч ангийн шалгаруулалтыг хоёр үе шаттай явуулжээ. Нийт 7200 гаруй цэргийн албан хаагч оролцсон эхний шалгаруулалтаас Зэвсэгт хүчний 013, 029, 032, 084, 120, 150, 326 дугаар анги, Дотоодын цэргийн 805 дугаар анги, Хилийн цэргийн 151 дүгээр ангиуд дараагийн шатанд шалгарч сүүлийн шатны шалгаруулалтад есөн анги өрсөлдсөнөөс тэргүүн байрт Зэвсэгт хүчний 032 дугаар анги шалгарч, хоёрдугаар байрт Зэвсэгт хүчний 150, гуравдугаар байрт Зэвсэгт хүчний 084, тусгай байрт Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн алба хаагчид тус тус шалгарлаа.

“Монгол цэргийн жавхаа” тэмцээний тэргүүн байрын шагналт, хурандаа н.Батболд ахлагчтай 032 дугаар ангийг 10 сая, хоёрдугаар байрт шалгарсан, хурандаа н.Гансэлэм ахлагчтай 150 дугаар ангийн алба хаагчдыг найман сая, гуравдугаар байрт шалгарсан, хурандаа н.Дамба ахлагчтай 084 дүгээр ангийнхныг зургаан сая, тусгай байр эзэлсэн, хурандаа н.Банди ахлагчтай 120 дугаар ангийн алба хаагчдыг дөрвөн сая төгрөгөөр тус тус шагнаж, урамшуулав. Шагналыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд хотын захирагч Э.Бат-Зүл гардуулж, тэмцээнд оролцсон Зэвсэгт хүчний нийт анги, хамт олон, дайчдад байр хүргэсэн юм.



Дрифтын тэмцээн

2014 оны 5 дугаар сар 17 нд Монголын мэргэжлийн спорт автомашин сонирхогчдын холбоо, Фортуна авто клубтэй хамтран дрифтын тэмцээн зохион байгуулав



Төр улсын хөгжил түмэн олны үйлс

5 сарын 27-28 өдөр Төр улсын хөгжил түмэн олны үйлс чуулганы үйл ажиллагааг Хүй долоон худгийн үйлчилгээний талбай дээр хамтран зохион байгуулав.

